



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 313

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, 2019 оны 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сэлэнгэ-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 114,808,070.00 (нэг зуун арван дөрвөн сая найман зуун найман мянга далан) төгрөгийн балансын үнэ бүхий автомашин, механизмыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Сэлэнгэ-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Ганболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлын хэсэг томилж, холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2019 оны 3 дугаар улиралд багтаан тайлангийн маягтаар ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТ ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Ц.ТҮВШИНЗАЯА



0000567

Төрийн өмчийн бодлого,
газрын 2019 оны 07 дугаар
өдрийн 373 дугаар тогтоо

"АНГЭ-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэл

Автомашинны марк, улсын дугаар, хөдөлгөөн, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/м/цаг/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	
Маркийн 29-34 СБА улсын өөрөө буулгагч, Арлын дугаар-559505	1990/1993	32179	975,500.00	975,500.00	-		
Маркийн 15-49 СБА улсын кран, арлын дугаар-0641336	1989/1986	2574	5,427,000.00	5,427,000.00	-		
Маркийн 29-45 СБА улсын өөрөө буулгагч, Арлын дугаар-558490	1993/1993	88700	3,165,750.00	3,165,750.00	-		
Маркийн, 74-43 УБ улсын дугаартай, хөдөлгөөний дугаар-B19500062	1995/2007		29,535,000.00	29,535,000.00	-	-	
Маркийн, 09-78 СБА улсын ачааны автомашин, арлын дугаар-23001047	1982/2005	389700	9,471,920.00	9,471,920.00	-	-	2
Маркийн, 70-66 СЭҮ улсын суудлын автомашин, арлын дугаар-YLNV96W9J000370	2008/2008	389210	43,750,000.00	43,750,000.00	-	-	2
Маркийн, 14-07 УН улсын дугаартай, хөдөлгөөний дугаар-219602	1990/1990	24976	3,256,200.00	3,256,200.00	-	-	
Маркийн, 14-08 УН улсын дугаартай, хөдөлгөөний дугаар-121928	1985/1985	10070	541,180.00	541,180.00	-		3
Маркийн, 14-10 УН улсын дугаартай, хөдөлгөөний дугаар-38327	1987/1987	12752	18,685,520.00	18,685,520.00	-		1
			114,808,070.00	114,808,070.00	0.00	0.00	1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			114,808,070.00 (нэг зуун арван дөрвөн сая найман зуун найман мянга далан)	114,808,070.00 (нэг зуун арван дөрвөн сая найман зуун найман мянга далан)			1 (нэг сая)